



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах.

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.



Улиастай хот 2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Аудитор Б.Мөнхнасан
Утас: 90066888
Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁОГ	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	4
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХУВААРИЛСАН БАЙНА.....	5-6
ДҮГНЭЛТ	7
ЗӨВЛӨМЖ:	8
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улсын төсвөөс хуваарилсан төсөв	4
2	Аймаг сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв	4
3	Аймаг сумын сонгуулийн хороодод ажилласан хүний тоо	5

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн сонгуулийн хороо болон Баянтэс, Идэр, Тэс сумдын сонгуулийн хороодыг хамруулан зардлын гүйцэтгэлд аудитыг хийсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300,400,3000-3100,4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “ Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, аудитор Б.Мөнхнасан хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХУВААРИЛСАН БАЙНА.

Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуулийн хүрээнд аймаг, сумын 4 сонгуулийн хороо, 3 хэсгийн хороо байгуулагдаж, 55 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс Аймгийн сонгуулийн хороонд 87.5 сая төгрөгийн 14 нэр төрлийн зардлыг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №1 Улсын төсвөөс хуваарилсан төсөв.

д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	167,000
2	Сургалтын зардал	1,275,000
3	Бичиг хэрэг	1,200,000
4	Шуудан холбоо	1,350,000
5	Унааны зардал	3,760,000
6	Санал авах байр бэлтгэх зардал	900,000
7	Сурталчилгааны зардал	2,100,000
8	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх	11,456,000
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	240,000
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	420,000
11	Томилолтын зардал	4,828,000
12	Шуурхай багийн зардал	860,000
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	51,891,750
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	7,146,000
	Дүн	87,593,750

Сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод төсөв хуваарилахдаа байршил, алслагдсан байдал, хэсгийн хороодын тоо, ажиллах бүрэлдэхүүнд үндэслэн хуваарилалт хийсэн байна. Үүнд:

Хүснэгт №2 Аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Аймгийн сонгуулийн хороо	28,331,800
2	Баянтэс сумын сонгуулийн хороо	19,100,150
3	Идэр сумын сонгуулийн хороо	18,643,200
4	Тэс сумын сонгуулийн хороо	20,393,600
	Дүн	86,468,750
	Үлдэгдэл төвлөрүүлсэн	1,125,000
	Нийт дүн	87,593,750

Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой бүрэлдэхүүнийг 6 хэсэгт хуваан хуваарилжээ.

Хүснэгт №3 Аймаг, сумдын сонгуулийн хороодод ажилласан хүний тоо.

д/д	Зардлын нэр	Сум, хэсгийн тоо	Ажиллах хүний тоо
1	Аймгийн сонгуулийн хороо	1	9
2	Сумын сонгуулийн хороо	3	17
3	Хэсгийн хороо	3	21
4	Мэдээлэл технологийн баг	1	1
5	Даамлын тоо	3	6
6	Нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан		1
	Нийт дүн		55

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан 87,5 сая төгрөгийн 98,7 хувь буюу 86,4 сая төгрөгийг бүрэн зарцуулж 1,1 сая төгрөгийн хэмнэлт үүссэнийг буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой өр, авлага үүсээгүй байна.

2. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн зардлын гүйцэтгэлийг хянаж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгсөн байна.

СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.10-т “Сонгуулийн Ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн Сонгуулийн хороо нь сум, дүүргийн Сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу 87,5 сая төгрөгийн санхүүжилтийг аймаг, сумдын Сонгуулийн хороодод хуваарилан, арвилан хэмнэлттэй зарцуулах, бүртгэлийн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх, тайлагнах, зарцуулалтын байдалд хяналт тавих тухай болон 2020 оны УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар цахим сургалт зохион байгуулж, үүрэг, чиглэл өгсөн байна. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдад хуваарилсан зардлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор сумдын Сонгуулийн хороодын санхүүгийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа ажилтны судалгааг гаргаж, фейсбүүк групп, мэйл хаягаар мэдээ, мэдээлэл, чиглэл өгч, төсвийн зарцуулалт, эсэх, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Нөхөн сонгуулийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан ажилласан байна.
2. Төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж өр, авлагагүй ажилласан байна.
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн анхан шатны баримтыг бүрдүүлж архивын нэгж үүсгэсэн байна.
4. Сонгуулийн зардлын хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

БАЙГУУЛЛАГААС ИРСЭН САНАЛ:


**ЗАВХАН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас: 7046-2454
Цахим шуудан: zavkhanelection@gmail.com
2026. 07. 21 № 14
танай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Завхан Аймгийн сонгуулийн хороо нь танай байгууллагаас ирүүлсэн 2026 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 375 албан бичигтэй танилцлаа санал үгүй болно.

ДАРГА  Т.РЭНЧИНВАНЖИЛ

